



**СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ**

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

**2019 оны 10-р сар**




## МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 17,922.82 **-5.5%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс, 8,263 **-8.7%**, МХБ-В индекс 7,482 **-1.6%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



## Олон улсын индексүүд

| Индекс          | 2019.09.30 | 2019.10.31 | Өөрчлөлт, % |
|-----------------|------------|------------|-------------|
| DJIA (US)       | 26,916     | 27,046     | 0.4%        |
| S&P 500 (US)    | 2,976      | 3,037      | 2.0%        |
| Nikkei 225 (JP) | 22,927     | 23,330     | 1.7%        |
| Hang Seng (HK)  | 26,092     | 26,906     | 3.1%        |
| DAX 30 (DE)     | 12,428     | 12,886     | 3.6%        |
| SMI (CH)        | 10,080     | 10,280     | 1.9%        |

## Валютын ханш

| Валют | 2019.09.30 | 2019.10.31 | Өөрчлөлт, % |
|-------|------------|------------|-------------|
| USD   | 2,667.21   | 2,701.17   | 1.27%       |
| EUR   | 2,916.46   | 3,014.51   | 3.36%       |
| JPY   | 24.73      | 24.87      | 0.56%       |
| RUB   | 42.26      | 42.32      | 0.14%       |
| CNY   | 374.10     | 383.96     | 2.63%       |
| KRW   | 2.23       | 2.32       | 4.03%       |

## Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

| Үзүүлэлт                      | Дүн     | Өөрчлөлт, % |
|-------------------------------|---------|-------------|
| Арилжааны хэмжээ, тэрбум ₮    | 6.9     | 118.5%      |
| Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮ | 2,402.5 | -3.01%      |
| Бүртгэлтэй компани            | 199     | 199         |
| Арилжаалагдсан хувьцаа        | 71      | 71          |
| Арилжаалагдсан өдөр           | 23      | 21          |

## Хамгийн их өсөлттэй

| Хувьцаа | 2019.09.30 | 2019.10.31 | Өөрчлөлт, % |
|---------|------------|------------|-------------|
| AOI     | 1,100.00   | 1,850.00   | +68%        |
| UID     | 807.18     | 1,250.00   | +54%        |
| BUK     | 382.00     | 449.00     | +17%        |
| GTJ     | 800.00     | 920.00     | +15%        |
| MRX     | 20.00      | 23.00      | +15%        |

## Хамгийн их бууралттай

| Хувьцаа | 2019.09.30 | 2019.10.31 | Өөрчлөлт, % |
|---------|------------|------------|-------------|
| BBD     | 170.00     | 91.00      | -46%        |
| BLC     | 1,495.00   | 1,100.00   | -26%        |
| MIK     | 14,390.00  | 11,000.00  | -23%        |
| TEX     | 10,200.00  | 8,000.00   | -21%        |
| LEND    | 50.64      | 42.82      | -15%        |

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

### "ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХК-ийн мэдэгдэл

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК (TSX:ERD; MSE:ERDN) нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас хувьцаанд хөрвөх нөхцөлтэй 6.6 сая канад долларын үнийн дүн бүхий зээл авах гэрээ байгуулсан байна. Мөн, Торонтогийн хөрөнгийн бирж дээр хаалттай хүрээнд нэмэлт үнэт цаас гаргах замаар 1.6 сая канад долларын үнийн дүн бүхий хөрөнгө татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй тухай мэдэгдсэн. Нийт 8.2 сая канад долларын дүн бүхий энэхүү нэмэлт санхүүжилтийг өөрийн 100%-ийн эзэмшлийн Хөндий алтны төслийн ТЭЗҮ боловсруулах, дизайн, техникийн зураг төсөл гаргах, ордын хайгуул, хөрөнгө оруулалт болон бусад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаануудад зарцуулах аж. Түүнчлэн, Хөндий алтны төслийн 2019 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөр эхэлснийг мэдээлжээ.

### "АТАР ӨРГӨӨ" ХК-ийн ТЕНДЕР АРИЛЖАА ХИЙГДЛЭЭ

"Таван богд инвест" ХХК-ийн зүгээс сайн дурын үндсэн дээр "Атар өргөө" ХК /MSE:ATR/-ийн нийт 174,136 ширхэг хувьцааг 60,200₮-өөр худалдан авах санал гаргасан юм. Энэхүү саналын дагуу компанийн 20.13%-ийг эзэмшигч "Таван богд трейд" ХХК, 19.93%-ийг эзэмшигч "Улаанбаатар гурил" ХХК болон 15 жижиг хувьцаа эзэмшигч нийлээд 4%-ийг, нийт 76,713 ширхэг хувьцааг 4.6 тэрбум гаруй төгрөгөөр худалдлаа. Ингэснээр "Атар өргөө" ХК-ийн хувьцааны төвлөрөл 84.05% болж нэмэгдэж байгаа бөгөөд үүнийн 44.05%-ийг "Таван богд инвест" ХХК, 40.00%-ийг "Бэрэн групп" ХХК эзэмшиж, үлдсэн 15.95%-ийг 340 гаруй хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

### "МОНОС ХҮНС" ХК-ийн шинэ үйлдвэр ондоо БАГТАЖ АШИГЛАЛТАД ОРНО

Энэ оны отгон IPO болох Монос хүнс ХК /MSE:MFC/ 2019 оны 3-р улирлын санхүүгийн үр дүнгээ танилцуулсан ба тайлангаас харахад компани 6.79 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 537 сая төгрөг буюу нэгж хувьцаандаа EPS=0.8₮-ийн цэвэр ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, борлуулалтын орлого 21%-иар өссөн ч ашигт ажиллагаа 3%-аар буурчээ. Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр шинээр ашиглалтад оруулах ажил нь тодорхой хэмжээнд хойшилсон ч одоогоор 90 орчим хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Компани үйлдвэрээ энэ ондоо багтаан бүрэн ашиглалтад оруулахаар зорин ажиллаж байгаа бөгөөд эхний ээлжинд нийт 15 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд танилцуулах юм байна. Түүнчлэн, Монос хүнс ХК нь Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлжээ. Ингэснээр компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнүүд нь олон улсад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөж, экспортын борлуулалт нэмэгдүүлэх таатай боломж нээгдэж байна.



Хамгийн их арилжигдсан

| Хувьцаа | Тоо ширхэг | Үнийн дүн, сая төг | Эзлэх % |
|---------|------------|--------------------|---------|
| AARD    | 270,785    | 412.6              | 22.01%  |
| AIC     | 406,752    | 292.3              | 15.89%  |
| INV     | 117,419    | 240.3              | 12.82%  |
| ADB     | 2,392,078  | 186.7              | 9.96%   |
| GOV     | 542,550    | 146.1              | 7.79%   |

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

| Компани | 2019.10.31 | Өөрчлөлт | Өөрчлөлт, % |
|---------|------------|----------|-------------|
| AOI     | 2.5        | 1.7      | +68.1%      |
| UID     | 29.7       | 16.2     | +54.8%      |
| BUK     | 50.2       | 8.8      | +17.5%      |
| GTJ     | 0.45       | 0.068    | +15.0%      |
| MRX     | 1.3        | 0.195    | +15.0%      |

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, тэрбум төгрөгөөр

| Компани | 2019.10.31 | Өөрчлөлт | Өөрчлөлт, % |
|---------|------------|----------|-------------|
| BBD     | 0.276      | 0.128    | -46.4%      |
| BLC     | 0.285      | 0.075    | -26.4%      |
| MIK     | 298.0      | 70.2     | -23.5%      |
| TEX     | 14.7       | 3.1      | -21.5%      |
| LEND    | 40.5       | 6.2      | -15.4%      |

**ҮЦТХТ-д 10-р сард нээгдсэн дансны мэдээлэл**

ҮЦТХТ-д 10-р сард нийт 43,078 данс нээгдсэнээс 16,339 данс шинээр, 26,739 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 16,329 дотоодын иргэн, 2 гадаадын иргэн, 8 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

**НОГДОЛ АШИГ ОЛГОЛТ**

МХБ-д бүртгэлтэй 32 хувьцаат компани 2018 оны санхүүгийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн. Үүнээс, 12 компани хувьцаа эзэмшигчдийнхээ үнэт цаасны дансанд ҮЦТХТ-өөр дамжуулан ногдол ашиг тараасан байна. Апу ХК ба Тавантолгой ХК нь тус бүр цэвэр ашгийнхаа 85%-ийг ногдол ашигт хуваарилсан бөгөөд нийт ногдол ашгийн дүнгээр тэргүүлжээ. Харин Гермес ХК нь жилд 2 удаа буюу хагас жил тутамд ногдол ашиг тараадгаараа онцлог бөгөөд сүүлийн жилүүдэд цэвэр ашгийнхаа 93% орчмыг хувьцаа эзэмшигчиддээ хуваарилсаар иржээ. Та ногдол ашгийн талаарх мэдээллийг дорх холбоосоор орж харна уу. [http://www.mse.mn/mn/dividend\\_info/123](http://www.mse.mn/mn/dividend_info/123)

Эх сурвалж: mse.mn, [mcsd.mn](http://mcsd.mn), marketinfo.mn

Та өөрөө гар утаснаасаа шууд арилжаа хийхийг хүсвэл манай “Цахим данс” системд бүртгүүлээрэй.

# “ЦАХИМ ДАНС” СИСТЕМ



<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment



Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайн арилжаа хийж, дансаа хянах боломжтой.



## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



### МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 9-р сарын эцэст 20.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.9 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.5 (13.9%) их наяд төгрөгөөр өссөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 9-р сарын эцэст 889.8 тэрбум болж, өмнөх сараас 35.9 (3.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 39.3 (4.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.


*Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг*

| Үзүүлэлт                | 2018.09  | 2019.08* |
|-------------------------|----------|----------|
| Мөнгөний нийлүүлэлт, M2 | 17,920.2 | 20,414.8 |
| Жилийн өөрчлөлт, %      | 21.4     | 13.9     |
| Сарын өөрчлөлт, %       | 2.7      | -0.3     |
| Нийт хадгаламж          | 12,222.7 | 13,686.5 |
| Жилийн өөрчлөлт, %      | 21.9     | 12.0     |
| Сарын өөрчлөлт, %       | 1.4      | -0.8     |
| Төгрөгийн хадгаламж     | 9,512.8  | 10,761.5 |
| Жилийн өөрчлөлт, %      | 28.1     | 13.1     |
| Сарын өөрчлөлт, %       | 1.0      | -0.8     |
| Валютын хадгаламж       | 2,709.9  | 2,925.0  |
| Жилийн өөрчлөлт, %      | 4.2      | 7.9      |
| Сарын өөрчлөлт, %       | 2.6      | -0.7     |

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9-р сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 105.2 (0.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.8 (11.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9-р сарын эцэст 985.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 3.2 (0.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 5.4 (0.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 9-р сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 59. (3.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 613.5 (45.1%) тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

*Зураг 30. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг*




### УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, түслэмжийн нийт хэмжээ 2019 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 7.7 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 484.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 9-р сард 872.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 35.1 (3.7%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 937.8 тэрбум төгрөг болж, 111.1 (13.4%) тэрбум төгрөгөөр өсчээ.

*Зураг 32. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг*




## Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



### ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 746.2 сая ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 435.2 сая ам. доллараар буурчээ. Урсгал данс 807.5 сая ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.0 тэрбум ам. доллар, анхдагч орлогын данс 1.0 тэрбум ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

*Зураг 33. Бараа болон үйлчилгээний худалдааны тэнцэл, сараар, сая америк доллараар*



### ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2019 оны эхний 9 сард дэлхийн 145 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.5 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 5.9 тэрбум ам. доллар, импорт 4.6 тэрбум ам. долларт хүрлээ. Харин

2019 оны 9-р сард экспорт 559.0 сая ам. доллар, импорт 507.5 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 256.6 сая ам. доллараар, импорт 76.5 сая ам. доллараар тус тус буурсан байна.

*Зураг 34. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар*




Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 911.0 (9.5%) сая ам. доллар, үүнээс экспорт 663.3 (12.6%) сая ам. доллараар, импорт 247.8 (5.7%) сая ам. доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 9 сард 931.7 сая ам. долларын ашигтай гарч байсан бол 2019 оны 9 сард өмнөх оны мөн үеэс 415.5 сая ам. доллараар өсч, 1.3 тэрбум ам. долларт хүрчээ.



### ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9-р сард улсын хэмжээнд өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны эцсээс 5.4%, өмнөх оны мөн үеэс 9.0%-р өссөн байна.

*Зураг 35. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь*



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9-р сард өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 15.6 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 37.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 8.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 14.4 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



## **Холбоо барих хаяг**

Стандарт инвестмент ҮЦК  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
6-р хороо, Бага тойруу 24,  
Монреимпекс ХХК-ийн байр,  
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433  
info@standardinvestment.mn  
www.standardinvestment.mn

### **Шуудангийн хаяг:**

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487  
УБ - 15160

## **Тодруулга болон мэдэгдэл**

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2019 *Стандарт инвестмент ҮЦК*